

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

**БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААН**



### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр, Мягмар гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5-24
<hr/>	
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	5-6
2.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 32 гишүүн 2023.01.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	6-17
3.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	17-24

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны 04 дүгээр сарын 04-ний өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 27 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Булгантуяа, С.Одонтуяа;

Чөлөөтэй: Ц.Анандбазар, С.Ганбаатар, Ч.Хүрэлбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл** /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 13

53.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд** /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 32 гишүүн 2023.01.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Г.Амартүвшин нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Ж.Батжаргал, Б.Жавхлан, Г.Тэмүүлэн нар уг хэлэв.

**Г.Тэмүүлэн:** Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.12.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Б.Уранчимэг, Хөдөө аж ахуйг дэмжих сангийн гүйцэтгэх захирал Б.Цогтсаран нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

**Г.Тэмүүлэн:** Төслийн 1 дүгээр зүйлийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** Төслийн 2 дугаар зүйлийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 6  
Бүгд: 11  
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын саналыг гаргав.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Тэмүүлэн:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн үг хэлэв.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун хариулж, тайлбар хийв.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

*Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Г.Тэмүүлэн:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооноос санаачлан боловсруулж хэлэлцүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 13 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 12 цаг 40 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨСВИЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 04 дүгээр сарын 04-ний  
өдөр, Мягмар гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
11 цаг 27 минут.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023  
ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР  
/МЯГМАР ГАРАГ/-ИЙН  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе.

Та бүхнээсээ хүлцэл өчье. Хоцорч орж ирлээ. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг Та бүхэнд танилцуулъя.

Ирцийн мэдээ. Ганибалын Амартүвшин гишүүн, Хавдисламын Баделхан гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Жамбын Батсуурь гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Болдын Жавхлан гишүүн, Лхагвын Мөнхбаатар гишүүн, Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Цэндийн Сандаг-Очир гишүүн, Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн, Баттогтохын Чойжилсүрэн гишүүн. Ингээд Ганзоригийн Тэмүүлэн миний бие гээд өнөөдрийн хуралдаан ирц олонх нь хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул Төсвийн байнгын хорооны 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаан нээснийг Та бүхэнд мэдэгдье.

Ингээд Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит

чуулганы 4 дүгээр сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа.

Хоёрдугаарт, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүд. 2023 оны 01 сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх байгаа.

Гурав дахь нь, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, анхны хэлэлцүүлэг нь байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэгдүгээрт,

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээрт сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолыг хэлэлцэж эхэлье.**

Тэгээд Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын даргын 2023 оны 56 дугаар захирамж гарсан. Энэ захирамжид Төсвийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд 4 дүгээр сард хэлэлцэхээр заасан асуудлыг Та бүхэнд бэлтгээд ингээд тараасан байгаа.

Байнгын хорооны тогтоолтой холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Байнгын хорооны тогтоолын тогтоолтой холбогдуулан уг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Ингэвэл “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Санал хураалтын дүнг танилцуулъя. Санал хураалтад нийт 13 гишүүн оролцсоноос 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.

11.30 цаг

Хоёр дахь асуудал.

**Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.**

Ингээд төсөл санаачлагчийн илтгэлийг миний бие Та бүхэнд танилцуулъя.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Төсвийн харилцааны эрх зүйн үндэс нь Монгол Улсын Үндсэн хуулиар тодорхойлогдсон үндэсний эдийн засгийн аюулгүй байдалтай холбогдох харилцаа бөгөөд энэ нь төрийн нийтийн өмчийг захиран зарцуулах үйл явцыг хуульчлан батлуулах үйл явц гэж ойлгож болно.

Үндсэн хуулийн дагуу иргэн бүр албан татвар төлөх үүрэгтэй бөгөөд төсөв бүрдүүлэх чиг үүргийг Монгол Улсын иргэн бүрд хүлээлгэсэн.

Улмаар нийт ард түмний төлсөн татварын хөрөнгөөр бүрдэх төрийн

нийтийн өмч болох төсвийг Үндсэн хуулийн дагуу Улсын Их Хурал төрийн бодлогод нийцүүлэн захиран зарцуулах бодлогыг тодорхойлж, хууль болгон баталдаг бөгөөд энэ нь төрийн нийтийн өмчийг захиран зарцуулах Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарах асуудал юм.

Энэ агуулгаар Төрийн нийтийн өмчийг захиран зарцуулах харилцаанд баримтлах зарчмыг Төсвийн тухай хуулийн 2012 оны шинэчлэлийн хүрээнд дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

Төсвийн тогтвортой байдлыг хангасан байх, төсвийн иж бүрэн үнэн зөв байдлыг хангасан байх, санхүү, төсвийн зохистой бодлогыг удирдлагыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангасан байх, хариуцлагатай байх гэсэн ч хуулийн хэрэгжилтийг дүгнэн үзэхэд дээрх зарчим энэ өнгөрөгч 10-15 жилийн хугацаанд үр дүнтэй хэрэгжиж чадаагүй байна гэж үзэж байна.

Тухайлбал, төсвийг боловсруулах, батлах үйл явцад иргэд олон нийтийн оролцоог хангах асуудал Төсвийн хуульд заагдсан ч Хууль тогтоомжийн хуулиар дээрх ил тодоор хэлэлцүүлэх асуудал алдагдаж иржээ.

Ил тод бус төсвийн харилцаанаас хариуцлага тооцох боломж байхгүй. Иймээс ч олон улсын жишгийн дагуу бид төсвийг ил тодоор хэлэлцүүлэн боловсруулдаг байх асуудлыг хуульчлах шаардлагатай байна гэж үзэж байна.

Түүнчлэн төсвийг боловсруулах, батлуулах үйл явц өөрөө үндэслэл, тооцоотой байж, Үндсэн хуульд заагдсан хөгжлийн бодлого төлөвлөлт тогтвортой байх нөхцөл бүрдэхээр байна. Гэвч Төсвийн хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр үйлчилсэн хугацаанаас хойш буюу 2012 оны төсвөөс хойших 10 жилийн хугацаанд нийт төсвийн хууль 10 удаа батлагдах ёстойгоос тодотгол хийж нэмэлт,



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

өөрчлөлт оруулснаар 23 удаа төсвийн хуулийг баталжээ.

Монгол Улс 2012 оноос хойш 2012, 2018, 19 оныг эс тооцвол бүх онуудад 1-2 удаа төсвөө тодотгож ирсэн нь төсвийн бодлого тогтворгүй, төсвийн тооцоолол бодитой бус байсныг илтгэж байна.

Монгол Улс 2012-2022 оны хооронд 10 удаа батлах ёстой дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл 30 удаа Улсын Их Хурлаар хэлэлцэн батлагджээ.

Үүнээс үзвэл төсөв тогтвортой, хариуцлагатай, ил тод байх нөхцөл хангалтгүй байна гэж үзэж болохоор байна. Төсвийн хүрээний мэдэгдлийн өөрчлөлт нь төсвийн хууль батлахтай зэрэгцэн байнга тодотгогдож ирсэн нь төсвийн тооцоолол бодитой бус байж ирснийг мөн илтгэж байна.

Түүнчлэн төсвийг боловсруулах түүний үндэслэл болох дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн тусгай шаардлагыг хэрэгжүүлэх гол үндэслэл болох Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ч өөрчлөх нөхцөлийг хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хийж иржээ.

Тодруулбал Төсвийн хуультай хамт хэрэгжиж эхэлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийт 13 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна.

Энэ нь жил жилийн Төсвийн хууль батлахтай зэрэгцэн өөрчлөгдөж ирсэн нь төсвийн тусгай шаардлагын босгыг Төсвийн хуульд нийцүүлэн өөрчилж ирснийг харуулж байна.

Төсвийн тусгай шаардлагад нийцүүлж төсөв батлах зарчим нь эсрэгээрээ төсөвтөө нийцүүлэн өөрчлөгддөг буруу жишиг тогтоосныг бид өөрчлөх шаардлагатай гэж үзэж байна.

Түүнчлэн Монгол Улсын жил жилийн төсвийн хууль тогтоомжийг батлуулах явцад үүсдэг хүндрэл нь өрийн тааз, өрийн хэмжээний талаар ихээхэн асуудал яригддаг ч өрийн удирдлагын тухай хууль тогтоомж болон төсвийн хууль тогтоомжид өрийг хэрхэн үүсгэх бодлогыг бодитой тодорхойлоогүй нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг зөрчих нөхцөл болж байна.

Засаглалын онолын дагуу Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих түүнээс хариуцлага тооцох эрх бүхий этгээд нь хууль тогтоох эрх хэмжээ бүхий Улсын Их Хурал бөгөөд энэхүү эрх хэмжээний хүрээнд Засгийн газрын боловсруулсан төсөв гүйцэтгэлтэй холбоотой хяналт тавих, хариуцлага тооцох нөхцөлийг нарийвчлан зохицуулах шаардлагатай гэж үзэж байна.

Энэ ч агуулгаараа төсвийн хуулийн дээрх зарчмуудыг хангах зорилгоор төсөв, санхүүгийн шинэчлэлийг хэрэгжүүлэх олон жилийн алдаа сургамжийг засаж залруулах үүднээс хуулийн төслийг боловсруулахдаа төсөв, санхүү, эдийн засгийн чиглэлийн их, дээд сургуулиудын эрдэмтэн, багш, судлаачид, эдийн засагчид, хувийн хэвшил, иргэний болон төрийн бус байгууллагын төлөөллийн ажил хэрэгч санал, зөвлөмжийг үндэслэн төсвийн шинэчлэлийн бодлого болгон дэвшүүлж байгааг хүлээн авна уу.

Үүнтэй холбоотойгоор төсвийн холбогдох 14 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг санаачлан Улсын Их Хуралд өргөн барилаа. Хуулийн төслүүдийг 30 гаруй гишүүн дэмжин гарын үсэг зурж, хамтран санаачлагчаар оролцож байна.

Хуулийн төсөл батлагдсанаар төсвийн тогтвортой байдлыг хангасан байх, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, хариуцлагатай байх зарчмуудыг зохих ёсоор шударгаар биелүүлэх нөхцөл бүрдэх юм.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Бид ардчилсан ёс, шударга ёсыг эрхэмлэн сонгогдсон тойрог, иргэдийнхээ төлөөлөл болон ажиллаж буйн хувьд ард түмнээс төрийн нийтийн өмчид төсөв болгон төвлөрүүлсэн хөрөнгийг ил тодоор төсөвлөх, захиран зарцуулах, уг хөрөнгийн тогтвортой байдлыг хангах, хариуцлагатай байх зарчмыг хуульчлах асуудалд анхааралтай хандах цаг нь болжээ.

Иймээс уг асуудлаар боловсруулсан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон дагалдах бусад хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд хэлэлцүүлэхээр танилцуулж байна.

Анхаарал тавьсан Та бүхэнд баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Хууль, тогтоолын төслүүдтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авцгаая.

Амартүвшин, Өнөрболор гишүүн. Үг дараа нь байгаа. Амартүвшин гишүүнээр тасаллаа. Жавхлан сайд асуулт асууя. Жавхлан сайдын микрофоныг өгье. Жавхлан сайдын микрофон. Ажлын албаныхан техникийн хүмүүст хэлээрэй. Жавхлан сайдын микрофон ажиллахгүй байна.

**Б.Жавхлан:** Баярлалаа. Байнгын хорооны дарга, гишүүдийнхээ өглөөний мэндийг хүргэе.

Сая төсөл санаачлагчийн илтгэлд дурдагдаж байгаа гол үзэл баримтлалыг бол Засгийн газрын зүгээс мэдээж дэмжиж байгаа.

Тэр нь төсвийн шинэчлэл гэдэг зүйлийг маш олон жил, үеийн үед л үе үеийн Сангийн сайд, үе үеийн Төсвийн байнгын хорооны дарга нар үүнийг ярьж, хэлж, хийж эхлүүлж ирсэн байдаг. Би ч гэсэн Төсвийн байнгын хорооны дарга

байхдаа энэ төсвийн шинэчлэлийн асуудлыг мөн л хүчтэй тавьж ингэж явуулж байлаа, тодорхой хэмжээнд. Тэгээд би нэг ийм зүгээр ажил хэргийн санал асуулт гэх юм уу даа тавих гэсэн юм.

Юу вэ гэхээр, төсвийн шинэчлэлийг том, нэлээн өргөн утгаар нь үр дүнтэй нэлээн системтэй тэгээд олон жил оршин тогтнохоор ингэж хийвэл илүү үр дүнтэй юм байна гэдгийг яг засагт орж ажиллаж байхад ингэж харж байгаа юм.

Тэгээд хуульд өөрчлөлт оруулах нэмэлт, өөрчлөлт оруулах хэсэг энэ төсвийн шинэчлэлийн томоохон хөтөлбөрийн би нэг хэсэг нь гэж ингэж харж байгаа юм.

Тэгэхээр Улсын Их Хурлаар хөтөлбөр батлуулаад, хөтөлбөр гэдэг маань зөвхөн төсвийн хуулиар хязгаарлагдахгүй. Төсвийн шинэчлэл гэдэг өөрөө төсвийн ерөнхийлөн захирагчийн шат бүрд нь төлөвлөлтөөс нь эхлээд л гүйцэтгэл, биелэлт гаргах гээд тэгээд эдийн засгийн хөгжилд мөн төсвийн хууль маань, төсвийн бодлого маань өөрөө нийцтэй байх гэдэг зарчмаараа төсвийн бүрэлдэхүүн хэсэг бүр өөрөө энэ шинэчлэлийг дэмжиж шинэчлэлийн нэг хэсэг нь байх ёстой.

Төсвийн урсгал зардал, төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл тусламж гээд төсвийн гадуур байдаг мөн бусад сангууд, нийгмийн даатгалын сан, эрүүл мэндийн даатгалын сан мөн одоо яригдаж байгаа нийгмийн даатгалын багц хууль ч гэсэндээ төсвийн хуулийн маш том чухал хэсэг нь. Одоо өргөн баригдчихсан байгаа Тендерийн тухай хууль ч байна. Энэ мөн л төсвийн шинэчлэлийн маш том хэсэг, Эрүүл мэндийн даатгалын багц хуулиуд байна.

Ингээд эдгээр хуулиудыг мөн ямар шинэчлэл рүү нь, ямар чиг хандлага руу нь хөдөлгөх ёстой вэ гэдгийгээ бодлогоор нь

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тодорхойлоод саяын Тэмүүлэн дарга яг хэллээ.

Эрдэмтэд, судлаачид, их, дээд сургуулиудын энэ чиглэлийн бүх багш, эрдэмтэд, мөн Засгийн газрын өөрийн ч судалгааны институц байна. Их Хурлын ч судалгааны институцүүд байна. Эд нарйгаа дахиж нэг сайн ажиллуулаад одоо ч ажиллаж байгаа зүйлүүд байгаа.

Ингээж гаргаж ирээд үүнийгээ нэг цогцоор нь нэлээн том тийм хөтөлбөр, бүр үндэсний хөтөлбөр хэлбэрээр төсвийн харилцаанд оролцож байгаа оролцогч бүр өөрсдийгөө төсвийн шинэчлэлийг хийх ёстой нэг хэсэг гэдгийг ухамсарлуулах ийм шатанд нь хийж хэрэгжүүлбэл илүү үр дүнд хүрэх болов уу л гэж ингээж Засгийн газар харж байгаа юм.

Тэгээд мөн өргөн барьсан Төсвийн хуульд орох нэмэлт, өөрчлөлтүүдийг Засгийн газар дээр бид яам бүр энэ дээр нэлээн ач холбогдол өгч, ингээж судалж саналуудаа өгсөн байгаа.

Тухайлбал, Төсвийн тухай хууль дээр 33 заалт бүхий нэмэлт ийм өөрчлөлт оруулъя гэсэн байна. Энэ дээрээс 26 заалтыг нь Засгийн газрын зүгээс цууд дэмжих боломжгүй юм байна гэсэн ийм санал өгсөн байгаа. Зүгээр эдгээр саналуудыг харгалзаж үзээд Их Хурал дээрээс Засгийн газар руу чиглэл өгдөг юм уу эсвэл.../минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Жавхлан сайдад 1 минут нэмье.

**Б.Жавхлан:** Баярлалаа. Тийм. Тэгээд Их Хурал дээрээс том ажлын хэсэг байгуулаад Засгийн газраасаа гишүүдээ оруулаад, эрдэмтэд тэр судлаачдаа оруулаад Төсвийн байнгын хорооны дарга өөрөө ахлаад, ингээд хэдүүлээ нэг хөтөлбөр хэлбэрээр гаргаад явбал яасан юм бэ гэсэн ийм ажил хэргийн санал асуулт байна.

**Г.Тэмүүлэн:** Жавхлан сайдад баярлалаа. Тэгэхээр бид бүхний хувьд яах вэ, төсвийн шинэчлэлийг өнгөрсөн хугацаанд тодорхой хэмжээнд үе шаттайгаар хийж ирсэн.

Тэгэхээр цаашидаа ч гэсэн ер нь энэ төсвийн шинэчлэл үргэлжилж хийгдэх, дээрээс нь болж өгвөл илүү том сууриар нь бодлогын түвшинд хийх зайлиггүй шаардлага байна гэж харж байгаа.

Тэгэхээр бидний хувьд энэ гол үндсэн энэ удаагийн шинэчлэлийн энэ асуудлыг оруулж ирж байгаа гол бодлогын асуудлууд маань нэг талдаа Улсын Их Хурлаас баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-30 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтод тусгагдсан энэ төсвийн хөрөнгийг эдийн засаг нийгмийн хөгжилд чиглүүлсэн үр ашигтай хариуцлагатай төсөв, санхүүгийн тогтолцоотой болох гэдэг юм уу, эсвэл мөн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих энэ үйл явцад хувийн хэвшил болоод иргэний нийгмийн оролцоо хангагдсан байх ч гэдэг юм уу. Эдгээр заалтуудын хүрээнд уялдуулж, хөгжлийнхөө бодлоготой уялдуулж ингээд төсвийн бодлогын шинэчлэлийг хийхээр ингээд төлөвлөж байгаа.

Тэгээд таныг энэ дэмжиж, одоо хамтарч ажиллаж, тодорхой энэ ажил хэрэгч саналуудыг гаргаж байгаад талархаж байна.

Тэгэхээр бид нэг талдаа үндсэндээ зөвхөн энэ удаагийн өргөн барьж байгаа энэ хуулийн асуудал бол зөвхөн суурь асуудлуудыг хөндсөн. Төсвийн хяналт, сахилга бат, хариуцлага, олон нийтийн оролцоо, төлөвлөлтийг сайжруулахтай холбоотойгоор эхний үе шатанд хийж байгаа ажил гэж бид хэд үзэж байгаа. Энэ ч үндсэндээ Төсвийн байнгын хорооны зүгээс өнгөрсөн оны төсөв батлагдсанаас хойших нь 4, 5 сарын хугацаанд ажиллаж хуулийн төслийг боловсруулсан.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Ер нь цаашидаа бид энэ төсвийн суурь тогтолцооны шинэчлэлийг мөн магадгүй энэ татварынхаа суурь системтэйгээ уялдуулж хийх шаардлага байна. Энэ магадгүй бид бүхний бодож байгаагаар дараагийн том шинэчлэлийн хүрээнд хийгдэх ёстой ажлууд гэж харж байгаа.

Энэ ажилд хамтран ажиллахаар санал гаргаж байгаа танд талархаж байна. Засгийн газрын зүгээс хуулийн төсөлтэй холбогдуулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд саналаа хууль санаачлагчид ирүүлсэн байгаа. 2023 оны 01 сарын 25-ны өдрийн 5 дугаар тэмдэглэлээр саналууд нь ирсэн.

Ингээд 01 сарын 31-нд хууль санаачлагчид албан бичгээр Хэрэг эрхлэх газраас ирсэн. Энэ саналуудтай ерөнхийдөө танилцаад эдгээр Засгийн газраас өгсөн саналуудын дийлэнх нь яг өргөн баригдсан төсөл дээр ерөнхийдөө бараг бүгдээрээ 80, 90 хувь нь шийдэгдсэн гэж бид харж байгаа. Засгийн газрын хуралдаанаар орсон хуулийн төсөл маань ерөнхийдөө нөгөө хууль өргөн баригдахаас өмнөх олон нийтээс санал авч байсан хуулийн төсөл дээр Засгийн газар яамнууд ажиллаад саналаа өгсөн байсан.

Тэгэхээр тэр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн төслөөс хойш Улсын Их Хуралд өргөн баригдсан хуулийн төсөл хоёрын хооронд нэлээн асар их зөрөө байгаа.

Тэгэхээр та бүхний одоо тэмдэглэлээр хүргүүлсэн саналуудын 80, 90 хувь нь тодорхой засагдаж, янзлагдаж тусгагдаад ингээд орсон гэдгийг танд хэлэх байна. Ингээд Улсын Их Хурлаас ер нь яг энэ төсвийн цогц бодлогын хүрээнд оруулж хөтөлбөр батлуулах, цогцоор нь хэрэгжүүлэх гэдэг таны энэ ажил хэрэгч саналтай хувь хүнийхээ үүднээс санал нийлж, бүрэн дэмжиж ажиллаж байна.

Тэгээд тэр дундаа энэ Эрүүл мэндийн даатгал, Нийгмийн даатгал,

татварын суурь систем болоод төсвийн суурь системтэй холбоотой асуудлууд дээр бид Улсын Их Хурал, Засгийн газар хамтарч ажиллаж энэ шинэчлэлийг хөгжүүлэх ёстой гэдэг хувь хүний байр суурьтай байна. Баярлалаа танд.

Амартүвшин гишүүн.

Жавхлан сайдын минутыг нэмье.  
Нэмж тодруулъя.

**Б.Жавхлан:** Баярлалаа. Яах вэ, миний санаа ингээд байгаа юм л даа, Тэмүүлэн дарга аа. Хэдүүлээ шинэчлэлээ яг томоор нь харж байгаа бол санал нийлж байгаа юм чинь ингэж яг хэсэгчилж ингэж нэг хуулиуддаа нэмэлт, өөрчлөлт оруулчихаар дараа нь өөрсдөө үүндээ хүлэгдээд, дараа дараагийнхаа шинэчлэлүүдийг хийж чадахгүй, шилжилт хийж чадахгүй иймэрхүү зүйлүүд болчих юм биш биз дээ. Тийм учраас эхнээс нь маш сайн судалгаа шинжилгээтэй, тооцоотой ямар ямар хуулиудыг хөндөх вэ, энэ бүгдийгээ цогцоор нь харж байгаад тэгээд ингээд дайрвал яасан юм бэ. Яг хуульдаа гар хурье гэж байгаа юм чинь.

Түүнээс биш бид одоо байгаа хуулийнхаа хүрээнд шинэчлэлээ маш зоригтой том салбаруудаараа хийгээд л явж байгаа. Алдаатай, оноотой, оносон нь хавьгүй илүү болов уу л гэж харж байна. Сая би тэр ковидын үед эрүүл мэндийн салбарт санхүүжилтийн томоохон өөрчлөлтийг хийлээ.

Боловсрол, соёл, спортын салбаруудад энэ жил үргэлжлээд ингээд хийж байна. Одоо ирэх жилүүдэд бид, ирэх жилүүдэд юу байх вэ. Одоо сүүлийн хагас жилд нийт төрийн албаны цалингийн тогтолцоог нь олон жил ингэж салангид явж ирснийг багцалж нэг мөр болгох гэж байна. Энэ маш том шинэчлэл болно. Төрийн үйлчилгээний салбар байна.

Тэгэхээр ийм шинэчлэлүүд ингээд явдагараа явж байгаа, ерөөсөө огт хийгдээгүй биш шүү. Энэ яг гүйцэтгэх

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

засаглалд ингээд дотор нь болж байгаа, энэ буцалж байгаа энэ өөрчлөлтүүд бол тэр болгон гадна тийшээ олон нийт рүү тайлагнаад байдаггүй. Гэхдээ үр дүнтэй нэлээдгүй ажлууд ингээд хийгдээд явж байгаа.

Тийм учраас тийм л санал юм байгаа юм нэг цогцоор нь хараад Төсвийн байнгын хороо энэ дээрээ манлайллаа авч яваад, тэгээд нэг үзвэл яасан юм бэ. Өшөө дахиад өргөн хүрээтэй үзвэл яасан юм бэ л гэсэн ийм санал байгаад байна.

**Г.Тэмүүлэн:** Санал гэж ойлголоо. Амартүвшин гишүүн асуулт асууя.

**Г.Амартүвшин:** Баярлалаа. Төсвийн шинэчлэл, ялангуяа энэ Их Хуралд байдаг эрхүүдийн хамгийн чухал нь л гэж би харж байгаа юм л даа, улсын төсвийг баталдаг. Тэгэхээр энд бид ингэж нэлээн тийм нухацтай хандахгүй байвал энэ их чухал процесс өөрөө их хүнд процесс.

Тэгээд нэгдүгээрт, би Засгийн газраас ямар ямар, энэ яг хуулийн төсөл дээр ямар саналууд өгсөн юм бол үүнийг ажлын албаныхан хуваалцаач, танилцъя.

Яагаад гэвэл би бол энэ хуулийн төслийг дэмжиж гарын үсэг зурсан, өргөн барьсан гишүүдийн нэг. Яагаад гэвэл би төсвийн шинэчлэлийг хийх ёстой гэж үзэж байгаа. Ялангуяа ил тод болгох, олон нийтэд нээлттэй болгох, олон талын оролцоотой болгох нь чухал. Гэхдээ энэ хуулийн төсөлд төсвийн шинэчлэлийг хүч түрж яаран ишидэж болохгүй гэж би үзэж байгаа.

Үүнийг ялангуяа Засгийн газартайгаа хамтдаа Сангийн яамтайгаа хамтдаа үүнийг хийх нь зөв өө. Бид нарын Их Хурлын гишүүдийн нүдээр харагдаж байгаа процесс яг амьдрал дээр Сангийн яамныхан болон Эдийн засгийн хөгжлийн яамныхан төсвийг батлуулдаг процесс, хэрэгжүүлдэг тэр ажил нь яг өөрөөр тусдаг байх гэж би хараад байна л даа.

Тэгэхээр ер нь сая Жавхлан сайдын санал болгож байгааг ер нь том зургаар нь харъя. Энэ зөвхөн Төсвийн тухай хууль биш ээ, дагалддаг хуулиуд нь биш, энэ том процессын шинэчлэл, реформ хийх шаардлагатай гэдэгт би ерөнхийдөө санал нийлж байна.

Тийм болохоор энэ юугаа өргөжүүлээд санаачилгаа, энэ нийгмийн даатгалын багц хууль байна, боловсролын багц хууль байна. Эдгээр хуулиудтайгаа хамтад нь үр дагавруудыг нь тооцож байгаад явуулбал яасан юм бэ. Ер нь яг энэ бидний өргөн барьсан хууль дээр Засгийн газрын зүгээс яг юу юун дээр нь санал нийлэхгүй байгаа юм бэ гэдгийг би мэдмээр байна л даа. Яг ямар зарчим санал нийлэхгүй байна гэдгийг. Түүн дээр нэг хариулт авчихъя.

**Г.Тэмүүлэн:** Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр үндсэндээ яг бид бүхний хувьд энэ төсвийн шинэчлэлийн хүрээнд хийгдэж байгаа магадгүй эхний үе шат гэж болох энэ төсвийн шинэчлэлийн энэ хуулийн өөрчлөлтүүд маань яг таны хэлж байгаа үндсэн суурь зарчмын хүрээнд хуулийн төслийг өргөн барьсан.

Тэр дундаа бид бүхний хувьд үндсэн 4 асуудлын хүрээнд хуулийнхаа төслийг боловсруулсан. Төсвийн төлөвлөлтийг сайжруулах, ил тод нээлттэй байдлыг дээшлүүлэх, төсвийн хяналт, хариуцлагыг сайжруулах. Мөн энэ тодорхой өр зээлийн бодлогыг тодорхой болгох хуульчлах гэдэг энэ үндсэн 4 бодлогын хүрээнд энэ төсвийн хууль болоод бусад дагалдах хуулиудад өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн барьсан.

Улсын Их Хурлын төсөв батлах процесс буюу түүний гүйцэтгэлийн тайланг батлах процесс маань нэг талдаа энэ өөрөө Улсын Их Хурлын Үндсэн хуулиар олгогдсон онцгой бүрэн эрхийн асуудлууд байгаад байгаа юм.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэгэхээр бид бүхний хувьд нэг талдаа энэ төсөвтэй холбоотой асуудалд илүү нухацтай хандаж, илүү энэ тодорхой өнгөрсөн 10, 15 жилийн хугацааны алдаа оноонуудыг дүгнэж цэгнэж, өөрчлөлт шинэчлэлтийг тодорхой хэмжээнд тасралтгүйгээр ингээд хийх ёстой гэж харж байгаа. Жавхлан сайдын хэлсэн саналтай би санал хэлж байгаа.

Тэгэхдээ энэ санал маань юу гэхээр хөгжлийнхөө бодлогын төлөвлөлттэйгөө уялдуулж, салбар болгоны уялдаа холбоог хангаж, магадгүй тэр эрүүл мэндийн даатгал болоод нийгмийн даатгалын тогтолцоотой холбоотой бүх салбар болгоны шинэчлэлийн асуудлуудыг төсөвтэйгөө уялдуулж хийх ёстой гэдэг саналууд байгаад байгаа.

Тэгэхээр энэ зарчмын хувьд бид үүнийг хийх ёстой. Тэгэхээр би хэлж байгаа санал бол одоо оруулж ирж байгаа төсөл нэг талдаа төсвийн шинэчлэлийн эхний үе шат. Энэ бол цэвэр төсвийн хяналт хариуцлагатай холбоотой, ил тод байдалтай холбоотой, төсвийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог бэхжүүлэхтэй холбоотой асуудлууд байгаад байгаа юм.

Тэгэхээр бид цаашид одоо юу гэдэг юм Жавхлан сайдын хэлж байгаа энэ хөгжлийн бодлогын төлөвлөлт болоод салбарын яамнуудтай хийгдсэний дараа, салбарын шинэчлэлүүд хийгдсэний дараа хийгдэх гэдэг юм уу энэ асуудал уялдуулах асуудлууд нэг талдаа бид бүхний хувьд дараагийн хоёр дахь үе шатны томоор нь татварынхаа суурийг, төсвийнхөө суурийг томоор нь хийх ёстой л асуудал байна гэж харж байгаа. Үндсэн энэ орж ирсэн хуулийн төсөл маань цэвэр төсвийнхөө сахилга батыг сайжруулах, хяналт, хариуцлагаа сайжруулах хүрээндээ л хийгдэж байгаа суурь зарчмын асуудлууд байна. Засгийн газраас ирүүлсэн санал маань 01 сарын 31-нд хууль санаачлагчид ирсэн. Бид бүхний

хувьд хуулийнхаа төслийг 01 сарын 16-нд байх аа, өргөн барьсан.

Тэгэхээр өргөн барьсны дараа Засгийн газрын санал ирсэн буюу сая энэ хаврын чуулгантай зэрэгцэж саналууд орж ирсэн байгаа. Тэгээд энэ хууль санаачилсан гишүүдэд энэ хуулийн төсөл Засгийн газраас өгсөн саналуудыг хүргүүлъя. Бид бүхний хувьд энэ саналуудыг бүх зүйл, заалт тус бүрээр нь судлаад тайлбар, дүгнэлтүүдийг гаргасан. Засгийн газраас ирүүлсэн санал маань нэг талдаа өмнөх 11, 12 сард олон нийтээс санал авч байсан эхний байдлаар хийгдсэн байсан хуулийн төсөл дээр санал ирүүлчихсэн байгаа.

Тэгэхээр Засгийн газраас өгсөн санал бид бүхний өргөн барьсан төсөл хоёрын хооронд нэлээн том зарчмын зөрөө өөрчлөлтүүд байгаа. Ерөнхийдөө Засгийн газраас дэмжихгүй гэдэг юм уу эсвэл тодорхой хүлээж авах боломжгүй байсан энэ саналууд асуудлууд яг өргөн баригдсан хуулийн төсөл дээр шинэчлэгдэж засагдаад, ерөнхийдөө суурь өөрчлөлтүүд хийгдчихсэн, зарчмын хувьд бидний хувьд үл ойлголцол үүсэх тийм асуудлууд бараг байхгүй ээ л гэж харж байгаа юм.

Амартүвшин гишүүн тодруулъя.

**Г.Амартүвшин:** Баярлалаа. Тэгэхээр би Жавхлан сайд нэгэнт байгаа юм чинь яг Жавхлан сайдын санал болгоод байгаа хувилбар нь яг чухам юу юм, юунд оршин тогтнох юм, яг ямар өөрчлөлт юм, бид нарын санаачилсан хуулиас ямар ялгаатай юм гэдгийг нэг тодорхой тайлбарлаад өгнө үү.

**Г.Тэмүүлэн:** Жавхлан сайдын микрофоныг өгье.

**Б.Жавхлан:** Баярлалаа. Энэ Төсвийн хууль, Төсвийн тогтвортой байдлын хууль, Гендерийн хууль, Өрийн удирдлагын тухай хууль гээд. Энэ хуулиуд яг Монгол Улсын ер нь эдийн засаг,

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нийгмийн амьдралд маш чухал нөлөөтэй ийм суурь хуулиуд байдаг.

Үүндээ гар үүрэгтэй бид бусад салбарын хуулиудын уялдаа холбоо тэгээд яг нөгөө төсвийн шинэчлэл гэж юугаа хэлж байгаа юм бэ гэдгийгээ маш зөв тодорхойлж, дунд урт хугацаанд гарах үр дагавар, энэ бүх юмаа тооцоолж, үүнийг хөтөлбөр болгож цогц арга хэмжээ болгож хийе ээ л гээд байгаа юм.

Өөрөөр хэлбэл энэ өргөн барьсныгаа түр хойшлуулаад, тэгээд хөтөлбөр дээрээ суугаад том хөтөлбөр гаргаж, Улсын Их Хурлаар батлуулаад ингээд Засгийн газар өөрсдөө ч идэвхтэй оролцоод Их Хурал дээрээс манлайллаа хийгээд ингээд явъя л гэж байгаа юм. Одоо бид энэ хуулийг ингээд явчих юм бол ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Жавхлан сайд нэмж тайлбар өгөх үү? 1 минут. Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Тэгээд арай өшөө цогц том хөтөлбөр болгож Улсын Их Хурлаараа батлуулаад, мэдээж төсөв батлах эцсийн эрх мэдэл Улсын Их Хурал дээр байдаг гэдэг маргашигүй шүү дээ. Энэ бол Үндсэн хуулийн өөрийнх нь ийм заалт, үүнийг хэн ч хэзээ ч алдаж чадахгүй. Ийм байгаа. Тэгээд Амартүвшин гишүүн тэр ямар заалтууд дээр санал зөрөөд байгаа юм бэ гээд, яах вэ би дахиад нөгөө хууль санаачлагчид маань өөрчлөлт хийчихсэн нь бид дээр ирээгүй учраас би хараагүй байгаа юм шүү, уучлаарай. Жишээ нь, ингээд тэр би нөгөө 26 гэсэн шүү дээ, 33-аас 26 дээр нь бид шууд дэмжих боломжгүй байна гэсэн байгаа юм.

Тэгээд тэндээс зүгээр би нэг гол 5 заалт нь ийм байгаа юм. Жишээ нь, тодотгол гэж байгаа юм. Тодотгол бол гэнэтийн асуудал байдаг, тодотгол хийе гэж бид төсвийг бүтнээр нь өмнөх жил нь баталдаггүй.

Тийм учраас тодотгол дээр жишээ нь ердийн хууль шиг ердийн

горимоор энд хэлэлцүүлэг хийгээд явах юм бол энэ нь өөрөө тодотгол биш болчихно. Цаг хугацааны хувьд ч амжихгүй, шаардлагатайгаа ч агуулга нь нийцэхгүй ийм тохиолдлууд амьдрал дээр гарна. Ер нь бол ямар ч ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн тогтоолын төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Өнөрболор гишүүнээр тасалъя. Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Баярлалаа.

Тэгэхээр төсвийн шинэчлэлийн асуудлыг бид нэлээдгүй ярьж байгаа. Гэхдээ аль ч цаг үед Улсын Их Хурал, Засгийн газар энэ төсөвтэй холбоотой шинэчлэлийн асуудлыг барьж ирсэн үнэн.

Тэгэхээр бид жилээс жилд энэ төсвийнхөө шинэчлэлийн асуудлыг ярьж, аль болохоор алсын хараатай байх тухай л асуудал байгаад байна л даа. Тийм учраас энэ төсвийн тогтвортой байдлын тухай асуудал, тусгай шаардлагын асуудал, түвшний асуудал гээд олон зүйлүүд байгаад байгаа юм.

Тийм учраас энэ бүх юмнуудаа ер нь нэлээн зөв харж, тэгээд энэ төсөв боловсруулахад баримтлах зарчим тэгээд олон нийтийн оролцоо, хэлэлцүүлгийн үе шат, энэ үйл ажиллагаанд оролцох ёстой байгууллагуудын хийвэл зохих ёстой ажил, хийгдсэн ажлын дүгнэлт, мэдээллүүдийг ер нь ямархуу байдлаар төсвийнхөө асуудалд бодож явах ёстой юм бэ?

Тэгээд хяналт, хариуцлагын тухай асуудал л энэ хуулиар зохицуулагдаж орж ирсэн гэж би ингэж ойлгож байгаа. Үүнийг хэлэлцэх эсэхийг нь дэмжье. Тэгээд тухайлсан заалтууд дээр нэгэнт хэлэлцэх эсэх нь чуулган дээр дэмжигдээд ороод ирвэл, ажлын хэсэг гарч тал бүрээсээ ярилцаж, өөрийнхөө онцлог

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нөхцөл байдалдаа нийцсэн байдлаараа сайжрагдах ёстой гэж би ингэж ойлгож байна. Нэг.

Хоёрдугаарт, төсвийн шинэчлэлийн хөтөлбөр гаргахыг бүрэн дэмжиж байна. Үүнийг харин өнөөдрийн хуралдаанаас бараг Засгийн газарт чиглэл өгчихмөөр юм байна, тэгээд боловсрогдоод ороод ирэг. Энэ хуулийн хэлэлцүүлгийн явцад орж ирвэл тэр орж ирж байгаа хөтөлбөр дээрээ бид асуудлуудаа илүү нухацтай ярих барих асуудлууд гарах байх. Тэгээд түүнийгээ дагаж эрх зүйн том шинэчлэл хийхдээ өнөөдрийн энд яригдаж байгаа асуудлууд маань биежээд, дахиад суугаад явах бололцоо нь хангагдаж байгаа учраас хэтийн их том зорилт хараад цаг хугацааны алдагдал хүлээж боломгүй санагдаад төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөлөл Их Хурлаар батлагдах ёстой. Нэг.

Хоёрдугаарт, төсөв боловсрогдох ёстой. Тэгэхээр энэ үйл явцуудад энэ шинэ харсан эрх зүйн зохицуулалтынхаа хүрээнд юмандаа анхаараад явж байх нь зохистой. Энэ нь зөв гэж бодож байна. Төсвийн шинэчлэлийн хөтөлбөрийг бид их олон талаас нь харах болно. Дан ганц тэр салбаруудын шинэчлэлийн асуудал ч биш ерөөсөө төрийн чиг үүргүүд түүнийг бусдаар гүйцэтгүүлэх ямар боломж байгаа юм. Төрийн өөрийнх нь бүтэц зардал өртгөө хямдруулах ямар боломж байгаа юм. Үүн дээр суурилж явах тухай гол асуудал яригдах ёстой.

Тэгээд дээр нь мэдээж төсвийн маань ил тод, хариуцлагатай, хяналттай байдал, төсвийн шат шатны эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудын эрх, үүрэг харилцааны зохицуулалтууд ч өөрөө эндээ орж байх ёстой.

Дээр нь бидний яриад байгаа тэр өнөө салбаруудад баримтлагдаж байгаа тэр гүйцэтгэлийн үр дүн дээр суурилсан үйл явц юмнуудыг илүүтэй нарийсгаж тодосгох ийм үйл явцууд энэ тэр гээд олон

зүйлүүд цааш цаашидаа яригдана гэж ингэж ойлгож байна.

Тийм учраас би 1 дүгээрт, энэ хуулийг өргөн барилцахад оролцсон хүн.

2 дугаарт, сая сүүлийн хувилбар юмнуудаа нэлээн сайн харж уншсан. Тэгээд энэ талаасаа харах юм бол энэ хуулийнхаа төслийг хэдүүлээ хэлэлцэх эсэхийг нь дэмжье. Тэгээд тодорхой ажлын хэсэг гарч илүү нарийсгаж сайжруулалтын юмнууд хийгдэх ёстой гэж ингэж ойлгож байна.

Хөтөлбөрийн асуудал цаг алдалгүй орж ирэх тэр юмнуудыг нь чиглэл болгоод өгчих нь зөв юм байна гэсэн ийм ойлголттой дэмжиж байна.

**Г.Тэмүүлэн:** Батжаргал гишүүнд баярлалаа. Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Би ер нь бараг дахиад л үгээ давтах нь дээ. Төсвийн шинэчлэлийн үзэл баримтлалыг 100 хувь дэмжиж байна, бараг 1000 ч хувь дэмжиж байна. Их Хурал дээрээс энэ удаа ингээд нэлээдгүй өргөн бүрэлдэхүүнтэй үүнийг ингээд дэмжээд явчихвал бүр их баяртай байна.

Гэхдээ бид нэг удаа ингэж хийх гэж байгаа бол маш амжилттай хиймээр байна, амжилттай хийх хэрэгтэй. Тэгэхгүй яг дараа дараагийнхаа шинэчлэлүүдийг нэг бүрэн харалгүйгээр бид урьдчилж ингэж дахиад өөрөө өөрсдөө тээг болохоор ийм юм болчих вий л гэж санаа зовоод байна л даа.

Яг бид чинь гүйцэтгэл дээр нь ингээд ажиллахаар амьдрал дээр их олон л юм гарч ирнэ. Одоо саяын түрүүн би хэлж амжаагүй, тодотгол, Өрийн удирдлагын тухай хууль, төсвийн хүрээний мэдэгдэл, хөрөнгө оруулалтууд, төсвийн ерөнхийлөн захирагч нарын тэр тооцоолол үндэслэлгүй тоон мэдээлэл эд нар гээд л бид нар Монгол Улсын эдийн засаг маань өөрсдөө бид урьдчилж харах



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

боломжгүй, өөрсдөөс шалтгаалдаггүй, маш том гадаад хүчин зүйлээс хамааралтай ийм эдийн засагтай улс шүү дээ.

Энэ бүгдтэй уялдуулж тэгээд бусад салбар хуулиуд өргөн баригдчихсан байгаа энэ юмнуудтайгаа нийлүүлээд, тэгээд илүү урт настай юм хийчихье ээ л гэж ингэж санал хэлээд байгаа юм.

Тэгээд үүнийгээ хэлэлцэхээ түр хойшлуулаад, тэгэхдээ үүнийгээ багтаагаад Байнгын хороон дээрээс үүнийг хөтөлбөрөө ахлаад, ажлын хэсэг байгуулагдаад ингээд яваач ээ л гэсэн ийм хүсэлт ийм санал тавиад байгаа юм. Үүнийг л нэг болгооно уу л.

**Г.Тэмүүлэн:** Өнөрболор гишүүн.

**Д.Өнөрболор:** Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Ер нь эдийн засагт энэ төсвийн бодлого маш чухал үүрэг гүйцэтгэнэ ээ. Тэгээд маш чухал хуулийн төсөл орж ирж байгаа. Цаг үеийн нөхцөл байдлаас ч харсан, төсвийн сахилга бат талаасаа ч харсан, олон нийтийн оролцоо талаасаа ч, мөн төсвийн суурь тогтолцооны шинэчлэх шинэчлэлийг яг хийх ёстой гэдэг нь ийм шаардлагаас ч харсан энэ хуулийн төсөл орж ирж байгаа. Миний бие энэ хуулийн төслийг дэмжсэн.

Энэ төсвийн шинэчлэл гэж олон жил л яриад байгаа гэж яриад байгаа болов ч манай улс 2000 оноос хойш энэ төсвийн зардлын бүтцэд бараг өөрчлөлт гараагүй, урсгал зардал нийт төсвийн 70 гаруй хувийг, хөрөнгийн зардал 20 орчим хувийг эзэлж ирсэн. Тэгэхээр энэ улс орнуудын ер нь тоон мэдээллээс ингээд харахад төсвийн зардлын хэмжээ нь тухайн улсын хөгжлийн түвшинээс ихээхэн хамаарч байдаг. Тухайлах юм бол дунджаас бага орлоготой улс орны төсвийн зардал хамгийн бага, тухайн улсын тод дотоодын нийт бүтээгдэхүүний 11 хувь орчимд

тэнцэхүйц хэмжээтэй байгаа бол дундаж орлоготой улсуудынх 14 хувь, дээгүүр орлоготой улсуудынх 15 хувь байгаа.

Тэгэхээр өнөөдөр манай улс ойролцоогоор 13.5 хувь буюу олон улсын түвшинтэй харьцуулахад дундаж болон дунджаас дээш орлоготой улс орнуудтай ойролцоо ийм судалгаа гарч байгаа. Харин энэ онд бүр 36-37 хувьтай тэнцэхүйц хэмжээний ийм зардалтай байгаа.

Түүнчлэн энэ гадаад өрийн нийт хэмжээний дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулсан харьцаа хөгжиж байгаа орнуудын өрийн хязгаар үзүүлэлтээс 2-3 дахин илүү байгаа.

Аудитын дүгнэлтээр 18-20 онд Засгийн газрын гадаад зээлийн 44.1 хувийг төсвийн алдагдлыг нөхөхөд зориулсан байж байгаа. Тэгэхээр ийм үр ашиггүй зардлын тэлэлт эдийн засагт олон сөрөг үр дагаврыг авчирч байгаа, дагуулж байгаа.

Тэгэхээр энэ төсвийн зардал нэмэгдэхэд төсвийн алдагдал нэмэгддэг, дагаад өр үүсдэг. Улмаар эдийн засгийн өсөлт саардаг, төгрөгийн гадаад валюттай харьцах хани суларч байгаа. Инфляц ч гэсэн өсөж үүний эсрэг Төв Монголбанк бодлогын хүүгээ өсгөж байгаа. Тэгэхээр ингээд энэ болгоноос болоод энэ зээл олголт ч хумигдаж байна. Бодит бизнесийн секторууд ч гэсэн шахагдаж байна. Уналтад орох ийм үндсэн гол шалтгаан болж байгаа.

Тэгээд ийм төсвийн оновчгүй ийм бодлого хэрэгжүүлж, мөчлөг дагасан шинжтэй явж ирсэн энэ байдлыг бид халах ёстой. Энэ нь өөрөө боловсрол, эрүүл мэнд, нийгмийн салбарт ч гэсэн сөргөөр нөлөө үзүүлж байгаа гэдгийг бид бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Худалдаа, хөрөнгө оруулалт ч татарч байна. Эдийн засгийн идэвхжил бүрэн энэ буурч байгаа яг энэ үед ханишийн сулрал, инфляцын

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

шалтгаан ч гэсэн болдгийг бид хангалттай л харж байна.

Тийм учраас энэ төсвийн төлөвлөлтөө, зарцуулалтаа бид сайжруулмаар байна, сахилга баттай болгомоор байна, тайлагналынхаа энэ хариуцлагыг сайжруулмаар байна, зардлынхаа өсөлтийг бүтээмжээр хэмждэг болмоор байна. Төсвийн бодлогыг эдийн засгийн өсөлтийг бий болгож чиглэсэн ийм цогц өөрчлөлт шинэчлэлт хийх нэн шаардлагатай.

Тийм учраас дэмжиж байгаа. Энэ сая Жавхлан сайдын яриад байгаа энэ Засгийн газрын 26 дэмжээгүй саналын талаар энэ өргөн баригдсан төсөлтэй хамт ирээгүй байгаа. Энэ талаар би мэдээлэл авахыг хүсэж байна. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Өнөрболор гишүүнд баярлалаа.

Тэгэхээр би яг яах вэ Жавхлан сайдын ажил хэрэгч саналыг зарчмын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ нэг талдаа юу гэдэг юм Жавхлан сайдын хэлж байгаатай холбогдуулж энэ удаагийн орж ирсэн төсвийн шинэчлэлийн энэ хуулийн төслүүдийг хөгжлийн бодлогын бодлоготой уялдуулах нь нэг талдаа энэ өрөөсгөл асуудал. Тэгэхээр бид зүгээр энэ удаагийн шинэчлэлийн асуудал маань цэвэр зүгээр ерөөсөө л төсвийн ил тод байдлыг хангахтай холбоотой, төсөвтэй холбоотой мэдээллийг нийтэд нээлттэй байлгахтай холбоотой, олон нийтийн оролцоо хяналтыг бүрдүүлэхтэй холбоотой.

Дээрээс нь тодорхой хэмжээнд төсөвт төсвийн тухай хуулиудад тусгагдаагүй байдаг төсвийн сахилга бат, хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулахтай холбоотой. Том зургаараа бид энэ өнгөрсөн 10, 15 жилийн хугацааны алдаа, оноогоо сайжруулах энэ эрх зүйн орчныг бүрдүүлэх л ийм хуулийн төсөл байгаад байгаа юм.

Бид бүхний хувьд гол мөрдлөг болгодог Төсвийн тухай хууль болоод Төсвийн тогтвортой хуулийн тухай хуулиудыг ер нь цаашид хэлбэрэлтгүй сахин мөрддөг байх энэ хүрээндээ үндэслэл шаардлагынхаа хүрээн дээрээ 15 жилийнхээ алдаа, онооныхоо хүрээн дээрээ хуулийнхаа төслийг боловсруулсан.

Тэгэхээр эргээд энэ нэг талаасаа ямар нэг байдлаар юу гэдэг юм Засгийн газраас оруулж ирэх эсвэл юу гэдэг юм ирэх оны төсөвтэй уялдуулж ямар нэг тээг, тушаа болох ч гэдэг юм уу ийм зүйлүүд нэг талдаа байхгүй. Хөгжлийн бодлоготой уялдуулах гэдэг саналтай зарчмын хувьд санал нийлж байна.

Тэгэхээр би энэ суурь зүгээр бид нар эхний шатны төсвийн шинэчлэлийн хуулиуд орж ирж байна. Мөн хэлэлцэх эсэхийг нь дэмжээд явсан тохиолдолд бид нар хэлэлцүүлгийн явцад ч гэсэн тодорхой хэмжээнд зарчмын зөрүүтэй үл ойлголцол үүсэх энэ асуудлууд байвал энэ дээр ажиллаад, байр сууриа нэгтгээд, тодорхой хэмжээний засвар нэмэлт, өөрчлөлтүүдийг хийгээд явах бүрэн боломжтой л гэж хувь хүнийхээ үүднээс үзэж байгаа.

Тэгэхээр бид цаашид энэ бодлогыг ямар нэг байдлаар ухраахгүйгээр, хойш тавихгүйгээр шийдээд явах ийм зарчмын энгийн бөгөөд энэ хуулийн асуудлууд орж ирсэн гэдгийг Та бүхэндээ эцэст нь хэлэх байна.

Тэгээд Та бүхнийг дэмжиж, энэ хуулийн төсөл дээр хэлэлцэх эсэхийг нь шийдэж өгөхийг хүсье. Тэгээд цаашид бид бүхэн илүү Байнгын хорооныхоо түвшинд ч, Их Хурал дээрээ ч гэсэн тодорхой асуудлууд дээр хамтарч ажиллаад явах бүрэн боломжтой гэж Та бүхэндээ хэлэх байна.

Ингээд хууль, тогтоолын төслүүдтэй, үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд үгээ хэлж дууслаа.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Санал хураалтыг явуулъя.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нь дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Та бүхэнд санал хураалтын дүнг танилцуулъя. Санал хураалтад нийт 12 гишүүн оролцсоноос 7 гишүүн дэмжиж, 58.3 хувиар дэмжигдлээ.

Ингээд хууль тогтоолын төслүүдийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж гишүүн танилцуулах уу. Пүрэвдорж гишүүн танилцуулна.

Ингээд Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэж дууслаа.

12.02 цаг

Дараагийн асуудалдаа орцгооё.

**Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.**

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танхимд оруулахыг хүсэж байна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ГТБХЗГ-ын дарга

Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал, ХХАА-г дэмжих сангийн гүйцэтгэх захирал Батжаргалын Цогтсаран, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Уранчимэг гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно гэсэн байгаа. Зүйл тус бүрээр нь.

Эхлээд Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл явна. Үүнтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? 1 дүгээр зүйлтэй холбогдуулж. Тогтохсүрэн гишүүн.

Асуулт асуугаад зарчмын зөрүүтэй санал гаргах

**Д.Тогтохсүрэн:** 2 юм байгаа юм.

Нэгдүгээрт, энэ Улсын Их Хурлын чуулган дээр хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх явцад гишүүдийн болгоомжилж байсан 2 зүйл байгаа юм. Үүнийг анхны хэлэлцүүлэг дээр бодвол яам. Байнгын хорооныхон ярилцаж байгаад тодорхой санал оруулж ирж байгаа болов уу гэж бодож байна.

Нэгдүгээр асуудал нь юу байна вэ гэхээр энэ сан бол их чухал ач холбогдолтой сан. Монгол Улсын тариалан цаашид төрийн дэмжлэг авч явдаг гол сан нь үүгээр дамжиж явж байгаа. Тэгэхээр энэ сан одоогоор маш их хэмжээний үлдэгдэлтэй, өртэй ийм сан бий. Нэгдсэн чуулган дээр 230 гаруй тэрбум төгрөгийн өртэй авлагатай гэж ингэж байгаа.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэгэхээр энэ сан нөгөө корпорац хэлбэр лүү шилжихээр өрийн асуудал дагаж явах тухай асуудал байгаа юм. Тэгээд ингээд өр нь дагаж яваад тэгээд дашин шог болоод замарчих вий гэж ингэж хүмүүс аягүй их болгоомжтой хандаж байна лээ. Өчигдөр хүртэл хэвлэлийн хурал дээр надаас асууж байна лээ, үүнийг, өчигдрийн бүлгийн хурлын дараа болсон. Тэгээд 1 дүгээрт, би үүнийг яаж явах юм бэ гэдэг асуудал.

2 дугаарт, цаашидаа Монгол төрөөс энэ газар тариалангийнхаа үйлдвэрлэлийг дэмжинэ, энэ дэмжихээс өөр арга байхгүй, манай стратегийн гол бүтээгдэхүүн. Гэтэл үүний дэмжлэг яаж явах юм бэ гэдэг асуудал байхгүй юу. Бид ингээд төрөөс жишээлбэл энэ жил гэхэд л зээлийн хүүгийн татаасыг хөнгөлж байгаа. Тэгээд магадгүй дараа дараа жилээс ингээд л зөндөө татаас янз бүрийн юм явна. Гэтэл энэ чинь корпорациар дамжиж явах юм уу, буцаад Засгийн газрын тусгай сангаа байгуулъя гээд ороод ирэх юм уу гэдэг асуудал байгаа юм.

Тэгээд энэ дээр хүмүүс нөгөө дэмжлэггүй болчих вий, корпорац руу шилжлээ, тариалангийн салбар дэмжлэггүй болчих вий гэдэг ийм л 2 зүйлийг нэгдсэн чуулган дээр нэлээн их ярьсан. Үүнийг бодвол манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Төсвийн байнгын хороо ярилцаж байгаад анхны хэлэлцүүлэгт оруулж ирэхдээ 1 ийм хэлбэрээр явъя гэсэн тодорхой зүйл давхацсан уу гэж би ингэж асуух гээд байгаа юм.

**Г.Тэмүүлэн:** Тогтохсүрэн гишүүний асуултад Ц.Болорчулуун дарга эхлээд хариулах уу.

Дараа нь би нэмэлт Байнгын хорооноос баримталж байгаа бодлоготой холбоотой оруулж ирэх асуудлаар тодорхой мэдээлье. Микрофон номер 1. Болорчулуун дарга.

Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун.

Тэгэхээр энэ Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт орж байгаа нь Хөдөө аж ахуйг дэмжих санг үндсэндээ үүнээс хуулиас байхгүй болгож байгаа ийм асуудал байгаа. Цаашидаа үйл ажиллагаа нь энэ төрийн өмчит хөдөө аж ахуйн корпорац төрийн өмчит компаниар дамжиж үйл ажиллагаа нь явах ийм зохицуулалттай байгаа. Компани байгуулагдчихсан байгаа.

Тэгэхдээ энэ дээр хуулийг дагаж гарах Их Хурлын тогтоолын төсөл явж байгаа. Энэ дээр ажлын хэсэгтэй яриад Байнгын хороотой яриад энд шилжиж байгаатай холбоотойгоор сан дээр байгаа өр, авлага, үндсэн хөрөнгө бүх зүйлийг ийшээ шилжүүлнэ. Энэ компани руу шилжүүлнэ гэсэн ийм шийдвэрийн төсөл дагалдаж орохоор байгаа. Тийм учраас энэ дээр ямар нэгэн хийдэл гарахгүй гэж ингэж харж байгаа.

Дэмжлэгийн тухайд энэ жилийн тухайд тухайлах юм бол энэ хүнсний хангамж аюулгүй байдал үндэсний хөдөлгөөнтэй холбоотой улсын төсөв дээр хүүгийн татаасны дэмжлэг тавигдсан. Энэ дэмжлэгүүд яаман дээрээс олгогдож байгаа, энэ сангаар дамжиж олгогдохгүй байгаа.

Тийм учраас энэ дэмжлэгтэй холбоотой асуудал яамаар тусдаа ингээд явчихна. Цаашидаа ер нь хөдөө аж ахуйн салбарт үзүүлэх дэмжлэгийн чиг, энэ цар хүрээг хуучин сангийн үйл ажиллагааны чиглэлд үндсэндээ 7 чиглэлд үйл ажиллагаа явуулдаг байсныг 16 болгож ингэж өргөжүүлж өргөтгөсөн байгаа.

Тэгэхээр энэ хуучин явж байсан дэмжлэгүүдийн хэлбэрийг арай өөр болгож бид энэ дээр энэ өргөжүүлсэн цар хүрээнийхээ хэмжээнд төрөөс үзүүлэх дэмжлэгийг энэ компаниараа явуулах ийм

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

бүрэн бололцоотой гэж ингэж тооцоолж тооцож үзсэн байгаа.

Тийм учраас энд дэмжлэг энэ компани байгуулагдсанаар явагдахгүй, дахиж сан байгуулах асуудал гарахгүй байх гэж ингэж харж байгаа юм.

**Г.Тэмүүлэн:** Тогтохсүрэн гишүүн тодруулъя. Тогтохсүрэн гишүүний микрофон нэмж тодруулна.

**Д.Тогтохсүрэн:** Тийм. Тэгэхээр ийм байхгүй юу. Сангаар явж байгаа, Засгийн газрын тусгай сангаар. Тэгээд энэ тусгай сан ингээд корпорацад шилжчихлээ. Давуу тал нь юу юм, ямар эерэг байдал бий болгох гээд байгаа юм энэ салбарт гэдэг л асуудал байхгүй юу.

**Г.Тэмүүлэн:** Асуултад хариулъя. Болорчулуун дарга 1 номер, 2 номер.

**Ц.Болорчулуун:** Тийм. Тэгэхээр одоо бол энэ газар тариалангийн ер нь хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл тэр дундаа газар тариалан, мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн цар хүрээ нэлээд өргөжиж байгаа юм.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор яг одоо энэ сангийн хүрээнд энэ хуулиар заачихсан энэ 7 чиглэлийн хүрээнд үйл ажиллагаа хумигдмал байгаад байгаа юм.

Тийм учраас энэ салбарт үзүүлэх дэмжлэг, энд оруулах хөрөнгө оруулалтыг татаж төвлөрүүлэх гээд энэ олон ажлуудыг цааш цар хүрээний хувьд өсөн нэмэгдэж байгаа цар хүрээтэй нь холбогдуулж хийхийн тулд компанийн үйл засаглалаар явах нь оновчтой гэж ингэж харсан. Сангаар байхаар сан өөрөө Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус ийм байгууллага байгаад байгаа юм.

Тэгээд энэ дээр үйл ажиллагааны зардал ч бид нэмж болдоггүй. Жишээлбэл яг төсөв дээр төсөвт тусгагдаж,

тэгэхдээ төсвөөс мөнгө авдаггүй хэдий ч санхүү ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Нэмж тодруулах уу.

Би Тогтохсүрэн гишүүний асуултад нэмээд Байнгын хорооноос ажиглаж байгаа талаар мэдээлэл өгье.

Тэгэхээр нэг талдаа Тогтохсүрэн дарга аа, ийм зүйл байгаа. Энэ хууль санаачлагчаас буюу Засгийн газраас орж ирсэн асуудал маань энэ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй орж ирсэн.

Нэг талдаа энэ хуулийн төслийг нь хууль санаачлагчид буцаах ёстой гэж үзэж байгаа, хууль санаачлагчид нь. Тэгэхээр бид тодорхой хэмжээнд энэ дээр өөрчлөлт оруулаад, хуультай нийцүүлэх үндсэн дээр тодорхой Улсын Их Хурлаас өөрөө хууль баталсантай холбогдуулж авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооноос санаачлаад боловсруулъя гэж ярьж байгаа.

Энэ Байнгын хорооны тогтоолын төсөл дээр юу орж ирэх вэ гэхээр ерөнхийдөө өмнөх энэ сангийн асуудал орж ирээд хэлэлцэх эсэхийг нь Улсын Их Хурлаар хэлэлцээд явж байхад Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан хэд хэдэн зарчмын саналууд байгаа.

Нэгдүгээрт, яам болоод бодлогын яаман доороо төрийн өмчийн компанитай, эргээд юу гэдэг юм аж ахуй үйл ажиллагаа эрхлэх ийм эрсдэлтэй нөхцөл байна. Үүнийг олон нийтэд нээлттэй компани болох гэдэг асуудлыг тавьсан.

Тэгэхээр хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний Улс Улсын Их Хурлын тогтоол буюу Байнгын хорооны санаачилгын тогтоолын төсөл дээр 1 дүгээр асуудал бол хөдөө аж ахуйн

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

корпорац төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн засаглалыг төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх хүрээнд газар тариалан, мал аж ахуй эрхлэгчдийн болон мэргэжлийн холбоодын оролцоог хангасан олон нийтэд нээлттэй компани болгох арга хэмжээг ав гэсэн чиглэлийг өгч байгаа юм. Нэгдүгээрх нь.

2 дугаар асуудал нь ерөөсөө энэ сангийн үйл ажиллагаа корпорацад одоо шилжиж байгаатай холбогдуулаад энэ хөдөө аж ахуйн санг татан буулгасантай холбогдуулаад тус сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй байгаа хөрөнгө, өр төлбөр, авлагыг хөдөө аж ахуйн корпорац төрийн өмчит энэ хязгаарлагдмал хариуцлагатай компанид бүрэн шилжүүлэх гэдэг 2 дугаар асуудал байгаа юм.

Энэ шилжүүлэхтэй холбогдуулаад дахиад гурав дахь асуудал нь ерөөсөө хөдөө аж ахуйн дэмжих сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй байгаа хугацаа хэтэрсэн өр авлага, эдгээрийгээ ангилаад улсын төсөвт төлөх өр төлбөрийг нь энэ 2024 ондоо багтааж төлж барагдуулах үйл ажиллагааг хууль тогтоомжид 2023 ондоо ч гэдэг юм уу хугацааг нь заагаад төлж барагдуулах үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлж зохион байгуул аа. Ямар нэг одоо юу гэдэг юм корпорацаас энэ компани руу шилжэж одоо юу гэдэг юм энэ сангаас корпорац руу шилжих хооронд ямар нэг энэ санхүүгийн талаас, үйл ажиллагааны талаас хийдэл гаргахгүй байх арга хэмжээг ав гэсэн энэ чиглэл өгөгдөж байгаа.

3 дахь үндсэн том асуудал нь яг ингээд Тогтохсүрэн гишүүний хэлж байгаатай холбогдуулаад ерөөсөө энэ цаг үе нь ч гэсэн яг ингээж таарч байна. Энэ хаврын тариалалт удахгүй эхлэх гэж байгаа. Тэгэхээр ерөөсөө энэ өмнө нь тариаланчдад үзүүлдэг байсан дэмжлэг гэдэг юм уу эсвэл тэр үйлчилгээ гэдэг юм уу энэ агро технологийг хугацаанд нь цаг

алдалгүй энэ газар тариалангийн салбарын үйл ажиллагааг хэвийн явуулах энэ нөхцөлийг бүрэн ханга. Өмнө нь энэ компани дээр байсан үүрэг, чиг үүргүүдийг бол сан дээр байсан үүрэг, чиг үүргүүдийг энэ компани руу бүрэн шилжүүл ээ. Ямар нэг энд бол үйл ажиллагаа талаасаа алдаа хийдэл гарах ёсгүй ээ гэсэн ийм тогтоолын төслийг Байнгын хорооноос санаачлаад Улсын Их Хурлын тогтоол болгоод Улсын Их Хурлаар оруулаад цуг батлаад ингээд явъя гэсэн ийм саналтай байгаад байгаа юм.

Тэгэхээр нөгөө эхлээд эхнийх нь хууль санаачлагчид нь буцаагаад Улсын Их Хурлаас яагаад, дараагийн нөгөө эцсийн хэлэлцүүлэг дээрээ хуулийнхаа төслийг ороод цохиод хамтад нь хэлэлцээд ингээд явна гэсэн үг байгаад байгаа юм. Хэрэв нөгөө дэмжигдвэл гэсэн үг шүү дээ Улсын Их Хурлаар энэ санал нь тийм ээ. Тэгээд ингээд л явна гэсэн ийм процедуртайгаар ямар ч бай Байнгын хорооны зүгээс Засгийн газрын ажлын хэсэгтэй хамтарч ажиллаад ийм хувилбар шийдэлд хүрсэн.

Тэгэхээр бол өмнө нь хэлэлцэх эсэхийг нь шийдэж байхад гишүүдээс тавьсан бүх саналууд ерөнхийдөө энэ тогтоолын хүрээнд шийдэгдэнэ ээ гэж харж байгаа.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт гишүүд асууж дууссан.

Энэ чинь санал хураалт явуулна тус бүрээр тийм ээ. Зүйл тус бүрээр.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан санал гаргах гишүүд байна уу? Алга байна.

Санал хураалтыг 1 дүгээр зүйлтэй холбогдуулж явуулъя. Санал хураалт.

Гишүүд анхааралтай хандаарай. Дэмжээд явах санал байгаа.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

11 гишүүн санал хураалтад оролцож, 6 гишүүн дэмжиж, 54.5 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна.

2 дугаар төсөл хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Хөөе, энэ санал уналаа. Гишүүд анхааралтай хандаарай. Өнөрболор гишүүн, Тогтохсүрэн гишүүд. Санал хураалттай 2 дахь, тийм.

Өнөрболор гишүүн санал гаргачих уу? Сая яалаа.

**Д.Өнөрболор:** Би сая, юу миний төхөөрөмж ажилласангүй ээ дарга аа, ахиад санал хурааж өгнө үү?

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа Д.Өнөрболор гишүүний саналаар 2 дугаар саналыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Санал хураалт, гишүүд анхааралтай хандаарай. 2, 3 санал байгаа.

Өнөрболор гишүүний хүчингүй болгох санал дэмжигдлээ. 54.5 хувиар.

Ингээд энэ санал дэмжигдсэнтэй холбогдуулж, хуулийн төслийн 2 дугаар төсөл дээр хураасан саналыг дахиж хураая. Санал хураалт гишүүд.

54.5 хувиар дэмжигдлээ.

3 дугаар зүйлтэй холбогдуулаад би нэг санал гаръя.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлийг хасах гэдэг санал гаргана. Хугацаатай

холбогдуулж гэж байгаа, тийм. Ердийн журмаар гэсэн үг. Энэ зарчмын зөрүүтэй саналыг гаргаж байна. Санал хураалтыг явуулъя.

54.5 хувиар дэмжигдлээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар асуулт сууж, санал гаргах гишүүд байна уу. Батжаргал гишүүн. Батжаргал гишүүн кнопоо дараарай, асуулт асуух кноп.

**Ж.Батжаргал:** Тэгэхээр энэ дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах гээд санал ороод ирчихсэн юм байна лээ. Гэтэл өнөө тусгай сангийн хууль дотроос яг энэ Хөдөө аж ахуйг дэмжих сантай холбоотой харилцаа нь хүчингүй болоод, сан татан буугдчихсан.

Тэгэхээр зэрэг угаасаа тэр тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль өөрөө үйлчлэх үйлчлэлгүй болчихож байгаа байхгүй юу.

Тийм учраас нэмэлт юу, журмын тухай хуульд нэмэлт оруулна гэхээсээ илүүтэйгээр журмын тухай хуулиа хүчингүй болгох ёстой юм биш үү? Үүн дээр ер нь ямар байр суурь байна вэ? Энэ дээр дэгийн ямар зохицуулалт байгаа юм бэ? Үүнийг 1 би тодорхой хариу авмаар байна.

2 дахь зүйл бол саяын ярьж байдаг энэ авч хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоолыг Байнгын хороон дээр санаачилж нэмэлт, өөрчлөлтийн хуультайгаа цуг батлах ёстой.

Тийм учраас би тогтоол санаачилж боловсруулах ёстой гэсэн ийм санал гаргаж байгаа юм.

**Г.Тэмүүлэн:** Болорчулуун дарга саяын Батжаргал гишүүний асуусан асуулттай холбогдуулаад тайлбар хийе. 2 номер.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Ц.Болорчулуун:** Батжаргал гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр энэ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хууль дээр болохоор хуучин ТЭДС, Мал хамгаалах сангийн санхүүгийн тайланд байгаа хөрөнгө, өглөг, авлагыг Хөдөө аж ахуйг дэмжих санд шилжүүлнэ гэсэн ийм заалт зохицуулалт байсан.

Тэгээд энэ утгаараа бид нар цаашилаад хөдөө аж ахуйн дэмжих сангийн хөрөнгө авлагын асуудал гарч ирж байгаа учраас энэ нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй юм байна гэдэг ийм утгаар л энд энэ заалтыг Журмын тухай хуульд оруулж ирсэн юм.

Одоо бол яг хууль талаасаа үнэхээр энэ шаардлагагүй гэж үзвэл бид нар үүнийг хүчингүй болгох боломжтой байх л гэж бодож байна. Тэгэхдээ яг энэ удаагийн бид нар энэ хэлэлцэж байгаа асуудлаараа хүчингүй болгох нь зүйтэй юу, нэг бол тусдаа асуудал байх уу гэдгийг хуулийн хүрээнд нь харах нь зөв байх л гэж бодож байна.

**Г.Тэмүүлэн:** Батжаргал гишүүн нэмж тодруулъя.

**Ж.Батжаргал:** Тийм. Аливаа хууль тогтоомжид бид нар өөрчлөлт юмнууд оруулж болно. Тийм учраас хууль хоорондын нийцлийг нь харах ёстой. Угаасаа энэ тусгай сангийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад тусгай санд багтаж байсан нэг санг нь татан буулгаад өөр хуулийн этгээд рүү хөрөнгө мөнгийг нь шилжүүлэхээр бид нар ярьчихсан.

Тэгэхээр зэрэг яг тэр тусгай сан дотор байж байсан тухайлсан тэр санг зохицуулж байсан Журмын тухай хууль үйлчлэх үйлчлэлгүй болчихож байгаа юм. Тийм учраас хууль хоорондын нийцлийг хангаж, тэр хуулиа хүчингүй болгохоос өөр арга бидэнд байхгүй ээ, юун нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох ёстой.

Харин залгуулаад одоо Хөдөө аж ахуйг дэмжих санд байж байгаа тэр үйл ажиллагааны чиг үүрэг нь, хөрөнгө санхүү нь, өр авлага нь энэ бүх хариуцлага уг шинээр байгуулагдаж байгаа хуулийн этгээд рүү шилжүүлэхээр тус дагасан ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Нэмж Батжаргал гишүүнд, та саналаа дуусгаад хэлчих.

**Ж.Батжаргал:** Тэгэхээр бид нар нэмэлт, өөрчлөлтийн хууль батлагдаж байгаатай холбогдуулаад авч хэрэгжүүлэх арга хэмжээний тогтоол баталъя. Тогтоол дотроо яг тэр Хөдөө аж ахуйг дэмжих сангийн чиг үүрэг, тэр үйлчилгээ, тэгээд хөрөнгө санхүү, өр авлага бүх зүйл шинээр эрх шилжиж байгаа тэр хуулийн этгээд рүүгээ бүгд шилжээд тэгээд энэ хөдөө аж ахуйн хөгжлийг тогтвортой хангах төрийн бодлого үйл ажиллагаа хэрэгжиж явах ёстой гэсэн ийм л зарчимтай байгаа.

**Г.Тэмүүлэн:** Засгийн газрын тусгай сантай холбогдуулаад Батжаргал гишүүн саналаа хэллээ.

Гаргах зарчмын зөрүүтэй санал байгаа юу? Батжаргал гишүүн зарчмын зөрүүтэй саналаа гаргая гэж байна.

**Ж.Батжаргал:** Яагаад хэлдэггүй юм, тэр чинь материал болж үлдэх л ёстой, би саналаа албан ёсоор хэлэх л ёстой биз дээ. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг дагаж мөрдөх юу, батлагдсантай холбогдуулаад дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг юу руу нь төсөл санаачлагч руу нь буцаачихмаар байна. Нэгдүгээрт, нэг ийм санал байна.

Хоёрдугаарт, ерөөсөө тэр журмын тухай хуулийг хүчингүй болгох санал гаргаж байна. Угаасаа уг хуулийн.

3 дахь санал. Нэгэнт дагаж мөрдөх журмын тухай хуулийг бид



2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

нэмэлт, өөрчлөлтийн төсөл өргөн баригч руу нь буцаагаад уг хуулийг хүчингүй болгож байгаатайгаа холбогдуулаад тусгай сангийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулж дагаж мөрдөх юу авч хэрэгжүүлэх арга хэмжээний Их Хурлын тогтоол баталъя гэдэг ийм саналыг оруулж байна. Тийм 3 санал. Нэгдүгээрт.

**Г.Тэмүүлэн:** Батжаргал гишүүний 3 санал гаргасан.

Би энэ дээр 1, 3 саналаас эхний санал нь хураах боломжтой. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, энэ Засгийн газрын тусгай сангийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гээд энэ нэгдүгээрх нь.

2 дугаар асуудал нь саяын таны гаргасан хүчингүй болох асуудлууд байгаа тийм ээ, өмнөх энэ хуулийн асуудал. Тэгэхээр энэ хуулийг бид Их Хурлынхаа дэгийн тухай хуулийн 40.3.1-ээр хууль санаачлагчийн өргөн мэдүүлээгүй хуульд өөрчлөлт оруулах нь өөрөө боломжгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ дэгийнхээ хуулиараа энэ 2 дугаар асуудал нь боломжгүй болчихож байгаа.

3 дугаар асуудал нь саяын тэр нөгөө Улсын Их Хурлын чуулганы хуралдааныхаа дэгээрээ бид хууль баталсантай холбогдуулж авах арга хэмжээний тухай хууль Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороо санаачлаад боловсруулаад хэлэлцүүлэх эрхтэй байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ 3 дээр саяын дунд талын асуудал дээр нь болохгүй, 2 асуудал дээр нь болно гэсэн үг. Тэгээд энэ 2 асуудлаар санал хураалтыг явуулъя гэсэн ийм саналтай байна.

Нэмээд яах вэ би зүгээр протоколд нэг зүйлийг тусгаад хэлчихье гэх гээд байгаа.

Сая Засгийн газар энэ хуулийн төслийг өргөн мэдүүлж оруулж ирэхдээ Сангийн яам болоод Хөдөө аж ахуйн яам 2 бол хууль зүй талаасаа дүгнэлт гаргах ёстой байсан. Энэ компанийг татан буулгах яг үндэслэл шалтгаан, энэ санг татан буулгах үндэслэл шалтгаан байсан эсэх талаар тэр дундаа Сангийн Яам энэ дээр голлох рольтой оролцож, яг мэргэжлийн санхүүгийн төсөв, санхүүгийн байгууллага яам талаасаа энэ талаараа шийдвэр гаргаж хүргүүлэх ёстой байсан.

Энэ талаар яг ийм шийдвэр гарсан уу, Засгийн газрын түвшинд. Тэр талаар нэг мэдээлэл өгөөч? Болорчулуун дарга.

**Ц.Болорчулуун:** Тэгэхээр Сангийн яам болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хамтарсан 2019-2020 оны сангийн санхүүгийн тайланд орсон санхүүгийн үйл ажиллагааны тайланд хяналт шалгалт хийсэн. Энэ хяналт шалгалтаараа цаашид энэ компанийн үйл ажиллагаа нь доголдсон. Тийм учраас энэ компанийн тухай Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.6.3-д заасны дагуу тусгай сангийн үйл ажиллагаа доголдсон үр ашиг нь үр ашиггүй болох нь тогтоогдсон гэсэн ийм дүгнэлт гаргасан байгаа.

Тэгэхээр энэ дүгнэлт бол бид нар бас энэ хурлын материалд хавсаргаад ирүүлсэн байж байгаа.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа.

Ингээд Батжаргал гишүүний гаргасан 2 саналаар санал хураалтыг явуулъя.

Зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

*1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. Гишүүд анхааралтай хандаарай. Санал хураалт.*

*54.5 хувиар дэмжигдлээ.*

*2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д заасныг үндэслэн Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооноос санаачлан боловсруулж хэлэлцүүлэх. Санал гаргасан гишүүн Батжаргал. Санал хураалт өгье. Санал хураалт.*

*54.5 хувиар дэмжигдлээ.*

*Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаарх Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батжаргал нэгдсэн хуралдаанд танилцуулна.*

*Ингээд хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.*

*Хуралдаанд идэвхтэй оролцсон Байнгын хорооныхоо нийт гишүүддээ баярлалаа.*

*Дууны бичлэгээс буулгасан:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ*

*П.ОЮУНГЭРЭЛ*